



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР



Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар

Мөрөн сум


1. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

1.1. Төрөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар 178 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19 тохиолдол буюу 11,9%-иар өссөн байна. Төрөлт Баянзүрх, Жаргалант, Их-Уул, Тариалан, Ханх, Цагаан-Уул, Хатгал сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Төрсөн эхчүүдийн 166 нь буюу 93,3 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Нийт төрөлтийн 0.6 хувийг гэрийн төрөлт эзэлж байгаа бөгөөд Хатгал суманд бүртгэгдсэн байна.

2025 оны эхний 1 сарын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 23,6 хувийг эзэлж, нийт төрөлтөөс 26.4 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 73,6 хувь нь хүндрэлгүй төрсөн байна. Төрөлтийн түвшин 1000 хүн амд 1,3 байна.



1.2 Хүүхдийн эрүүл мэнд

2025 оны эхний 1 сарын байдлаар улсын хэмжээнд 179 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 18 хүүхдээр буюу 11,2 хувиар өсчээ.

Амьд төрсөн хүүхдийн 53 буюу 52,0 хувь нь хүү, 86 буюу 48,0 хувь нь охин байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 108,1 хүү ногдож байна.

Амьд төрсөн нийт хүүхдээс 6 нярай буюу 3,4 хувь нь 2500 грамаас доош жинтэй, 1 тохиолдол буюу 0,6 хувь нь төрөлхийн гажигтай төрсөн байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 99,4 байна. Дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 78,2 байна. Тухайн сард амьгүй төрөлт бүртгэгдээгүй байна.

2025 оны эхний 1 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад 3587 хүүхэд хамрагдсанаас 0.1 хувь нь туранхай, 0.1 хувь нь тураалтай байна. 73.6 хувь нь Д амин дэм, 10.8 хувь нь олон найрлагат бичил тэжээл, А амин дэмийг 9 хүүхэд хэрэглэсэн байна.


1.3. Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Сүүлийн 5 жилийн дундажаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 107,1 байна.

1.4. Нялхсын эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар нялхсын эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

2024 оны нялхсын эндэгдлийн шалтгаан нь амьсгалын тогтолцооны эмгэг, төрөлхийн гаж хөгжил тус бүр 1 тохиолдол бүртгэгдсэн байна.




1.5. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2024,2025 оны эхний 1 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол тус тус бүртгэгдээгүй байна.

1.6. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор буурсан байна.



2. ХҮН АМЫН НАС БАРАЛТ


2025 оны эхний 1 сарын байдлаар улсын хэмжээнд нас баралтын 52 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 12 тохиолдлоор өссөн байна.

Нийт нас баралтын 27 тохиолдол буюу 51.9 хувь нь эрэгтэй, 25 буюу 48.1 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 23.1 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 7 тохиолдол буюу 58.3 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор өссөн байна.


Нас баралтын түвшин 1000 хүн амд 0.4 байна.

Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 1.6
2. Хавдар-0.7
3. Гадны шалтгаант өвчлөл- 0.6
4. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-0.3
5. Амьсгалын тогтолцооны өвчин-0.1



Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 9 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 17.3 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор өссөн бөгөөд 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 0.7 байна.




4. ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ


2025 оны эхний 1 сарын байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэгт нас баралтын 9 тохиолдол бүртгэгдсэнээс 22,2 хувьд нь эмгэг судлалын болон шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийгдсэн байна. Аймгийн хэмжээнд үндсэн оношийн зөрүү бүртгэгдээгүй байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 7 тохиолдол байна.

5. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

5.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар нийт 72981 эмчийн үзлэг хийгдсэнээс 42.3 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 41.4 хувийг өвчний учир амбулаторт, 5.8 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 9.6 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 240.9 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урьдчилан сэргийлэх үзлэг 28902 буюу 39.6 хувиар өссөн байна.





5.2 Жирэмсний хяналт

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 171 эмэгтэйчүүд хамрагдсан ба 94.7 хувь нь эхний 3 сартайд, 5.3 хувь нь 4-6 сартайд хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 95.3 хувь нь цусны шинжилгээнд цус багадалттай жирэмсэн эмэгтэй бүртгэгдээгүй байна.

Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз болон заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 94,7 хувь, тэмбүү болон ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 99,4 хувь нь хамрагдсан байна.



5.3 Үр хөндөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар нийт 3 эмэгтэйчүүд үр хөндөх мэс ажилбарыг хийлгэсэн ба нийт үр хөндөлтийн 1 тохиолдол буюу 33,3 хувийг хожуу үр хөндөлт, 3 тохиолдол буюу 100 хувийг өсвөр насны үр хөндөлт эзэлж байна.

5.4 Халдварт бус өвчлөл

2025 оны эхний 1 сарын байдлаар халдварт бус өвчлөл 10554 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 1666 тохиолдлоор өссөн байна. 10000 хүн амд 768,0 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 65 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 0,6 хувийг эзэлж, 10000 хүн амд 4,7 байна.


Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 197.2
2. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-136.9
3. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 120.1
4. Нүд ба түүний дайврын өвчин-69.2
5. Мэдрэлийн тогтолцооны эмгэг-65.2


5.5 Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 6352 (7,3%) хүн хамрагдсан бөгөөд 41,2 хувь нь эрэгтэй, 58,8 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 11,4 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна.


Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 4936 (9,2%) хүн хамрагдсанаас 40,7 хувь нь эрэгтэй, 59,3 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 17,6 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна.




Элэгний эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр





16-65 насны БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



5.6 Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 413 (4,4%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй гарсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 2835 (6,6) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт (1,7%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг, үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.



5.7 Түргэн тусламжийн дуудлага

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар 1798 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 14,9 хувь /268/ нь алсын дуудлага, 1,7 хувь /31/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 59,9 дуудлага, АНЭ 15,3 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

5.8 Хэвтэн эмчлүүлэгсдийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар 2885 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 19223 ор хоног ашигласан байна. Аймгийн дунджаар ор ашиглалтын хувь 79,4 дундаж ор хоног 6.7 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 77 хүнээр, ор хоног 783 тохиолдлоор тус тус буурсан байна.

6. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 19978 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 61.5 хувь
- Өвчний учир үзлэг 11.3 хувь
- Диспансерийн хяналт 9.4 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 17.2 хувь
- Гэрийн дуудлага 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 700 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 4.6 хувийг, томуу томуу төсст өвчин 14,7 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 63 жирэмсэн эмэгтэйгээс 88.2 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 22 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 6 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 5, осол гэмтлийн нас баралт 4 тохиолдол, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл тохиолдол бүртгэгдээгүй байна.

7. ХУВИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 4092 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 9.3 хувь
- Диспансерийн хяналт 3.9 хувь
- Өвчний учир үзлэг 86.7 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 898 хүн хэвтэн эмчлэгдэж, 6456 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.2 орны эргэлт 2.7 ба орны фонд ашиглалт 19.6, орны фонд ашиглалтын хувь 71.1 байна.

Нийт халдварт бус өвчний 802 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 59 тохиолдол бүртгэгдсэн байна.

8. ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар 7 төрлийн 89 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 6.5 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор буюу 10 000 хүн амд ногдох өвчлөл 0.7-аар өссөн байна.

10 000 хүн амд ногдох халдварт өвчнийг сумуудаар харьцуулбал: Алаг-Эрдэнэ (9.0), Төмөрбулаг (11.4), Улаан-Уул (9.3), Шинэ-Идэр (9.6), Цагааннуур (14.7), Мөрөн (11.9) сумууд аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.


8.1. Халдварт өвчний нас баралт

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар халдварт өвчний нас баралтын тохиолдол бүртгэгдээгүй байна.

8.2. Цочмог халдварт өвчин

Нийт цочмог халдварт өвчний 48 тохиолдлоос:

- Цусан суулга 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хоолны хордлого 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор буурч
- Сүрьеэ 6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Ёлом 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Салхинцэцэг 37 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 18 тохиолдлоор тус тус өсч
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.



8.3. Амьсгалын замын халдварт өвчин



2025 оны эхний 1 сарын байдлаар аймгийн хэмжээнд амьсгалын замын халдварт өвчний 43 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 48,3 хувийг эзэлж байна. Амьсгалын замын халдварт өвчин өмнөх оноос 20 тохиолдлоор өссөн байна.

8.4. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин

2025 оны эхний 1 сарын байдлаар аймгийн хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварт өвчний 41 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 46,1 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор буурсан байна.

Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 31.7 хувийг тэмбүү, 65.9 хувийг заг хүйтэн, 2.4 хувийг трихомониаз тус тус эзэлж байна.


- Тэмбүү 13 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор
- Трихомониаз 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор тус тус өсч
- Гонококкт халдвар 27 тохиолдол буюу өмнөх оны мөн үетэй адил тохиолдол бүртгэгдсэн байна.



9.ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

2025 оны эхний 1 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 56 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс цэврүүт тууралт 85.7 хувь (48), цочмог цусархаг тууралтат 14.3 хувь (8) тус тус бүртгэгдсэн байна.




Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/



Тохиолдлын нэр	2024 он		2025 он	
	бодит тоо	дүнд эзлэх хувь	бодит тоо	дүнд эзлэх хувь
Цочмог халууралт тууралтат				
Цочмог цэврүүт тууралтат	30	76.9	48	85.7
Цочмог цусархаг суулгалтат	8	20.5	8	14.3
Цочмог усархаг суулгалтат				
Хоолны хордлогот халдвар	1	2.6		
Нийт	39	100.0	56	100.0

9.ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН

2025 оны эхний 1 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 2966 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 215.2 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 1633 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 118.5 болсон байна.



ХЯНАСАН:

ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
М.ҮҮРИЙНБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА